

Г.Гантулга, СЭЗДС, МВА, дэд профессор
gantulga.g@ife.edu.mn

П.Доржпүрэв, СЭЗДС, МВА
dorjpurev.p@ife.edu.mn

У.Дөлгөөн, Оюу толгой ХХК-д санхүүгийн шинжээч, МВА
dulguun@ot.mn

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛД НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАГНАЛЫГ НЭВТРҮҮЛЭХ НЬ

Abstract

Now is the time that world puts its attention to corporate social responsibility matters and both those who operate in environmental and social responsible way and their services or products are more welcomed by public than other who don't act in such way. CSR helps not only companies but also countries to maintain their reputation and increase competitive advantages.

In Mongolia, CSR is relatively new as there are not many research works have been done and companies have different understanding of what CSR is, CSR reports and also country jurisdiction itself hasn't yet fully embraced CSR at various level such as in strategy, legal system etc.

This research work will aim to study worldwide CSR practices including its development, current trend as well as evaluate CSR of mining industry in Mongolia to identify improvement needs and produce appropriate approach to meet those needs for mining companies.

This research work will aim to study worldwide CSR practices including its development, current trend as well as evaluating CSR of mining industry in Mongolia to identify improvement needs and develop an appropriate approach to meet those needs for mining companies.

Хураангуй

Компанийн нийгмийн хариуцлагын асуудалд дэлхий нийтээр анхаарал хандуулж, ихээхэн ач холбогдол өгөх болсон бөгөөд нийгэм, байгаль орчин, эдийн засагт эерэг нөлөөлөл бүхий үйл ажиллагаа явуулдаг байгууллага, компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийт нааштайгаар хүлээн авч, нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаагаар дамжуулан компаниуд төдийгүй улс орнууд ч өөрийн нэр хүндийг өсгөх, өрсөлдөх чадвараа сайжруулах боломжийг бий болгож байгаа юм. Манай улсад нийгмийн хариуцлагын талаар үйл ажиллагаа, тайлагналын орчин хөгжлийн эхэн үедээ явж буйг энэ талаар хийгдсэн судалгаа бүтээлүүдийн хомс байдал, компаниудын НХТ-н ойлголтын зөрүү, ялгаатай тайлагнал, стандарт дүрэм журмын хэрэгжилтийн хяналт сул байгаагаас харж болно. НХТ-ын талаар нэгдсэн ойлголт, хууль эрх зүй, дүрэм журам, стандартыг удирдан чиглүүлэх алсын хараа, стратеги бодлого зохицуулалт манай улс орны бодлогын хүрээнд шаардлагатай байгаа юм. Энэхүү судалгааны ажлаар ОУ-ын түвшин дэх НХ-ын тухай ойлголт, НХТ-н үүсэл хөгжил, орчин цагийн НХТ-ын талаар судалж Монгол улсад тэр дундаа УУ-н салбарын НХТ-г олон улсын туршилагад тулгуурлан сайжруулах арга замыг тодорхойлохыг зорьсон бөгөөд компаниудын үйл ажиллагаанд НХТ хэрхэн тус нэмэр болох мөн НХТ-ын орчны нэгдсэн мэдээллийн сан, дүн шинжилгээ хийх үндэс суурьт бага ч болов хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Энэхүү судалгааны ажлаар ОУ-ын түвшин дэх НХ-ын тухай ойлголт, НХТ-н үүсэл хөгжил, орчин цагийн НХТ-ын талаар судалж Монгол улсад тэр дундаа УУ-н салбарын НХ болон НХТ-д үнэлэлт өгөх, олон улсын УУ компаниудын НХ болон тайлагналын туршилагад үндэслэн компаниуд хэрхэн нийгмийн хариуцлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар зөвлөмж бэлтгэн хүргэхийг зорив.

Түлхүүр үг: Компанийн нийгмийн хариуцлага /КНХ/, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга /ОУИТБС/, Нийгмийн хариуцлагын тайлагнал /НХТ/, Нэгдмэл тайлагнал /НТ/, Тогтвортой байдлын тайлагнал /ТБТ/, Нийгмийн хариуцлагын олон улсын стандарт /НХОУС/

ОНОЛЫН ХЭСЭГ

- 1. Компанийн нийгмийн хариуцлага, нийгмийн хариуцлагын тайлагналын үүсэл хөгжил**

Хариуцлагатай байдлын тухай ойлголтыг анхлан 1987 онд НҮБ, тодруулбал Bruntland-н тайланд буюу олон улсын хэмжээнд “Хариуцлагатай буюу тогтвортой хөгжил нь хойч ирээдүй үеийн хэрэгцээгээ хангах чадамжинд сөргөөр нөлөөлөлгүйгээр өнөөгийн хэрэгцээгээ хангах явдал” хэмээн тодорхойлогдож байсан бөгөөд энэхүү тодорхойлолт нь эдийн засаг, нийгэм, байгаль орчны хоорондын хамааралтай байдал, үе хоорондын цаг хугацааны хэлхээ холбоосыг онцлон дурдсан. (Jones, 2010)

Дэлхийн олон улс орнууд нийгмийн хариуцлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлж түүнийгээ НХТ-аар дамжуулан хөрөнгө оруулагчид болон сонирхолын бүлгүүдэд хүргэх болсон ба тайлагналыг сайн дурын болон заавал бэлтгэх гэсэн хоёр зарчмаар улс орнууд хэрэгжүүлж байгаа юм. Үндэстэн дамнасан томоохон корпорациудын хувьд сайн дураар НХТ-ыг бэлтгэж ирсэн боловч сүүлийн жилүүдэд тайлагналыг улс орнууд, хөрөнгийн биржүүдийн зүгээс заавал тайлагнахаар шаардах эсэх талаар хэлэлцүүлгүүд өрнөх болсон. Үүний үр дүнд Франц, Швед гэх мэт зарим улс орнууд НХТ-ыг заавал бэлтгэхээр зааварчлаад байгаа юм. Ийнхүү сайн дурын тайлагналыг заавал тайлагнах тайлагнал болгон өөрчилж байгаа нь олон талын ач холбогдолтой бас дутагдалтай тал ч ажиглагдаж байгаа юм. Сайн дурын тайлагналын хувьд сайн талууд байгаа боловч зарим нэг сорилтуудтай тулгарч байна. Үүнд:

- Компаниуд тайлагналын хамаарах цаг хугацааг өөр өөрөөр (жилээр, хагас жилээр, ганц удаа, харилцан адилгүй давтамжтай) сонгох
- Мэдээллийн харилцан адилгүй байдал буюу нэг салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниуд өөр хоорондоо ялгаатай үзүүлэлтүүдийг сонгон тайлагнах
- Харилцан адилгүй формат, харилцан адилгүй хэмжүүр ашиглах мөн компаниуд ижил үзүүлэлтүүд дээр тайлагнасан ч мэдээллийн хамаарах цаг хугацаа өөр, өөр хэмжүүр ашигласан, харьцуулсан мэдээлэл ялгаатай зэрэг асуудлуудыг дурдаж болно.

Харин албан журмын тайлагнал нь дээрх асуудлуудыг шийдэхээс гадна НХТ-ыг зарим талаар сайжруулах боломжийг олгодог. Үүнд:

- Корпорациуд тогтвортой хөгжлийн асуудалд хамаарах чухал ач холбогдол бүхий мэдээллийг ил тод тайлагнах тайлагналын түвшин, орон зайг тодорхойлж бий болгох
- Хөрөнгө оруулагчид болон бусад сонирхолын бүлгүүдэд нэг салбар дахь компаниудын нийгмийн хариуцлагын талаар мэдээллийг ижил нөхцлийг ханган харьцуулан дүгнэх боломжийг бий болгох
- Сонирхолын бүлгүүдийг бүхэлд нь компанийн үйл ажиллагааны нөлөөллийн талаар мэдээлээр хангаж, эрүүл шүүмж хэлэлцүүлэг хийх боломж олгох
- Гуравдагч этгээд компаниудын нийгмийн хариуцлагын бодлого, хэрэгжүүлэлтэд үнэлэлт, дүгнэлт өгөх
- Зэрэгцээ компаниудын бодлого хэрэгжүүлэлттэй харьцуулах, тогтвортой хөгжлийн зорилгодоо хүрэх үйл явц болон дутагдалтай талуудыг үнэлж дүгнэлт өгөх
- Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлж байгаа мөн хэрэгжүүлэхгүй байгаа корпорациуд төр засгийн зөв, тогтвортой хөгжил бүхий нийгмийг цогцлооход үйл явцад хэрхэн хувь нэмэр оруулж буйг ойлгох зэрэг сайн талуудыг дурдаж болно.

Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл их уул уурхай, химийн бодис, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэгч, газрын тос ба газ зэрэг салбаруудад үйл ажиллагаа эрхлэгч томоохон компаниуд НХТ-ыг хурдацтайгаар хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд CorporateRegister.com-д дурдсанаар 2008 оны эхний 9 сарын байдлаар үйл ажиллагаагаараа томоохонд тооцогдох 80 гаруй химийн бодис үйлдвэрлэгч компаниуд, уул уурхайн компаниуд 80 гаруй НХТ, газрын тос болон газ үйлдвэрлэгчид нийт 200 гаруй, цахилгаан эрчим хүчний компаниуд 230 гаруй НХТ-ыг тус тус бэлтгэн гаргасан. Мөн түүнчлэн KPMG 2008 оны 10 дугаар сард нийтэлсэн судалгаанаас харахад Global Fortune 250 компаниудын 80 орчим хувь нь НХТ-ыг бэлтгэсэн ба энэ тоо нь 2005 онд 50 хувьтай байсан байна. (Steve Lydenberg, Jean Rogers, David Wood)

Ийнхүү сайн дураар НХТ-ыг бэлтгэх компаниудын тоо хэмжээ өссөн нь корпорациуд болон сонирхолын бүлгүүдийн НХТ-д өгөх ач холбогдол өндөр байгааг харж болно.

2. Монгол Улсад

1991 онд өмч хувьчлалын хуулийг баталж, үйлдвэрүүдийн газруудыг хувьцаат компани болгох ажлыг эхлүүлсэн ба уг оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Монголын хөрөнгийн биржийг байгуулж

байсан түүхтэй. Цаашлаад 1999 онд компанийн тухай хууль батлахдаа зэрэгцээд анх удаа “Компанийн засаглалын зарчмууд”-ыг мөн баталсан нь компанийн нийгмийн хариуцлагын суурь үндэс гэж хэлж болох засаглалд ач холбогдол өгсөн анхны чухал арга хэмжээ болсон юм. Өнөөгийн байдлаар манай улсад КЗ-ын кодекс, НХ-н стандарт /ISO26000/, НББОУС, СТОУС, Ил Тод Байдлын Санаачилга зэрэг олон улсын стандарт, дүрэм журмууд хэрэглэгдэж эхлээд байна.

Тайлагналын хууль эрх зүйн зохицуулалт, дүрэм журам, стандарт

Монгол Улсын Их Хурлаас 1993 онд анх “Нягтлан Бодох Бүртгэлийн Тухай” хууль, 1996 онд “Аудитын тухай” хуулиудыг тус тус баталж, Монгол Улсад Нягтлан Бодох Бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн бүртгэл хөтлөх асуудлыг хуульчилсан.

Ил Тод Байдлын Санаачилга

Манай орон Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга-д 2006 онд нэгдэн уг оны 7 дугаар сард ашигт малтмалын тухай хуульд нэмэлт заалт оруулж, олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллага, компаниудыг тусгай зөвшөөрөл эзэмшигч улс болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөрийн талаар жил бүр ил тод тайлагнахыг хуульчилсан. Анх 2008 оны 5 дугаар сард Монгол улсын ОУИТБС-ын анхдугаар нэгтгэл тайланг бэлтгэсэн байдаг.

Компанийн Засаглал

Монгол компаниудын засаглалын үнэлгээний тайланг Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хороо болон Компанийн Засаглалын Хөгжлийн Төвтэй хамтран Олон Улсын Санхүүгийн Корпорациас хамгийн сүүлийн байдлаар 2013 онд 2011 оны мэдээлэл дээр үндэслэн гаргасан байна. Уг үнэлгээнд хөрөнгийн биржид бүртгэлтэй Монголын томоохон гэгдэх 20 компаниудын КЗ-н хэрэгжилтийн байдлыг авч судалсан. Судалгааны дүнд уул уурхайн компаниуд КЗ үнэлгээнд доогуур байрыг эзэлсэн байна.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

1. Оюу Толгой ХХК ба ВНР Billiton компаниудын нийгмийн хариуцлагын тайлан

Монгол Улсын Хөрөнгийн Биржээс Монголын компанийн засаглалын кодекс, Компанийн засаглалтай холбоотой журам зааврын үлгэрчилсэн зааврууд, Жилийн үйл ажиллагааны тайлан бэлтгэх тухай зөвлөмж мөн ХК өөрийн цахим хуудсанд Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд зориулсан цэстэй байх зэрэг кодекс, заавар зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхийг ХК-дад зөвлөдөг боловч хэрэгжилтийг хуульчилж өгөөгүй учир ХК-ууд сайн дурын үндсэн дээр эдгээрийг мөрдлөг болгоно.

Жилийн үйл ажиллагааны тайлан нь ерөнхийдөө КНХТ-тай төстэй бөгөөд одоогийн байдлаар 7 хуудас бүхий зөвлөмжөөс өөр тайлагналын стандарт, дүрэм журам байхгүй байна.

ОУИТБС-аас гаргасан тасралтгүй 7 жилийн турш тайлагналаа ирүүлсэн уул уурхайн компаниудаас нийт 7 хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компаниудыг сонгон авч тэдгээрийн нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн тайлагналын өнөөгийн байдлыг авч үзэхэд 2 хязгаарлагдмал хариуцлагатай компани л хугацааны хувьд хамгийн сүүлийн байдлаар 2013 онд НХ, ТХ-ийн тайлагналыг бэлтгэж олон нийтэд нээлттэй толилуулсан байгаа нь өнөөгийн уул уурхайн компаниудын НХ болон НХТ-ын түвшин сул байгааг харуулж байгаа юм.

Хувьцаат компаниудын хувьд жилийн гүйцэтгэлийн тайлагналыг бэлтгэх талаар хөрөнгийн биржийн зөвлөмж байдаг боловч хэрэгжүүлэлт байхгүй байгаа нь энэ төрлийн тайлангууд олон нийтэд ил тод биш байгаагаас мөн харж болно.

1.1.1. Тогтвортой хөгжлийн тайлагнал ВНР Billiton

Дэлхийд томоохонд тооцогдох уул уурхайн компаниудын нэг ВНР Billiton тогтвортой хөгжлийн тайлагналыг тогтмол бэлтгэн толилуулдаг бөгөөд ОУТС-аас боловсруулсан зөвлөмжийг баримтлан тайлагнадаг. Компани уг зөвлөмжийн дагуу нийгмийн хариуцлагын үндсэн ойлголтуудын хүрээнд тайланг бэлтгэж байна. Үүнд:

- Засаглал

- Үйл ажиллагааны шударга байдал
- Бизнесийн ил тод байдлыг хангах
- Уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх
- Ажилчид
 - Ажилчид болон үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах
 - Ажилчдын эрүүл мэндэд анхаарах
 - Манай ажилчид
- Байгаль орчин
 - Хүлэмжийн хий
 - Биологийн төрөл зүйлс болон газрын хэвлийн ашиглалт
 - Усны хэрэглээ
- Нийгэм
 - Орон нутгийн хамтын ажиллагаа, дэмжлэг үзүүлэх
 - Хүний эрхийг дээдлэх
 - Нийгэмд үзүүлэх эерэг нөлөөлөл зэрэг нийт 4 үндсэн бүлэг болон дэд бүлгүүд багтдаг.

Тайлангийн эхэнд компанийн зорилго, үнэ цэнийг тодотгон тусгаж өгсөн бөгөөд нийгмийн хариуцлагатай буюу тогтвортой хөгжлийн асуудал үүнд багтсан байна. Ингэснээр тайланг уншигчдад компани үйл ажиллагаандаа нийгмийн хариуцлага тодруулбал эрүүл, аюулгүй ажиллагаа, байгаль орчинд ээлтэй байдал мөн орон нутгийг дэмжих асуудлыг тусгадан ажилладаг болохыг харуулж байгаа юм.

ВНР Billiton тогтвортой хөгжлийн тайлагналд бас нэгэн онцлох зүйл бол бизнесийн оролцогч талуудыг тодорхойлж тэдгээрийн хүсэн сонирхол юу болох тэдний шаардлагын хариуд компани ямар үйл ажиллагаа явуулж байгаа талаар товч бөгөөд тодорхой тайлбарласан байна.

ТБТ бэлтгэх нь олон удаагийн давтамжтай үйл явц бөгөөд стандартад зааснаар ТБТ-ыг бэлтгэхэд тодорхой үе шатуудыг дамждаг байна. Мөн ТБТ-ыг бэлтгэхэд гол чухал асуудал бол материаллаг талуудыг тодорхойлох явдал юм. Тэдгээр материаллаг талууд нь байгууллагын эдийн засаг, байгаль орчин, нийгмийн эсвэл сонирхлын бүлгүүдийн шийдвэр гаргалт, үнэлгээнд нөлөөлөх гол нөлөөлөл бүхий асуудлууд юм.

1.1.2. Оюу Толгой ХХК- нийгмийн хариуцлагын тайлан

Оюу Толгой ХХК-ний үйл ажиллагаа нь Монгол улсын эдийн засагт ихээхэн нөлөөтэй бөгөөд 2006 оноос хойш Рио Тинто, Туркойз Хилл Ресурс нар ойролцоогоор 6.2 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг төслийн хөгжүүлэлтийн ажилд зориулсан ба төслийн нийт ажилчдын 90 гаруй хувийг Монгол ажилчид бүрдүүлж байна. 2013 оны 6 дугаар сарын байдлаар Оюу Толгой нийт 1.1 тэрбум ам.долларыг татвар хураамж, болон бусад төлбөрөөр дамжуулан Монгол улсын засгийн газарт төлөөд байгаа юм. Компанийн байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлого үндсэн 5 чиглэлд хэрэгждэг бөгөөд тус бүрийн бодлого, зарчим, хэрэгжилтийн талаар товч авч үзье.

Боловсрол ба сургалт

Рио Тинто компанийн албан ёсны вэб хуудсанд тэмдэглэснээр Оюу Толгой төсөл нь сүүлийн 5 жилийн турш нийт 126 сая ам. долларын хөрөнгө оруулалтыг зөвхөн боловсрол, сургалтын үйл ажиллагаанд оруулсан бөгөөд барилга байгууламж, мэргэжлийн сургалтын төвүүдийг нийт 7 хот, суурин газруудад байгуулаад байгаа юм байна. Тооцооллоор 6,600 хол давсан хүмүүс эдгээр сургалтын төвүүдэд бэлтгэгдэх бөгөөд 1,200 гаруй мэргэжлийн сургалтын төвүүдэд багшлах багш, сурган хүмүүжүүлэгч нарыг Боловсролын Яамтай хамтран сургаж, бэлтгэж байна. Мөн түүнчлэн Оюу Толгой оюутан залуусыг дотоодын ба олон улсын их дээд сургуулиудад суралцахад нь дэмжлэг үзүүлж тэтгэлэгт хөтөлбөрийг зарлан явуулдаг.

Байгаль орчин

Өмнийн говь байгалийн өвөрмөц экосистемтэй, малчид зонхилсон оршин суугчидтай гэдэг утгаараа Оюу Толгой онцгой бөгөөд мэдрэмтгий байгаль орчинд үйл ажиллагаагаа явуулж байна. Оюу Толгойн бүтээн байгуулалтыг энэ төрлийн бусад олон улсад үйл ажиллагаа явуулдаг уурхайнуудтай харьцуулахад усны хэрэглээг хамгийн зөв зохистой байлгахгаар төлөвлөсөн бөгөөд үйл ажиллагаандаа хэрэглэсэн усны 80 орчим хувийг, хэрэглээний усыг бүхлээр нь дахин ашиглахаар бүтээн байгуулалтыг гүйцэтгэсэн байна.

Мөн түүнчлэн уурхайн эргэн тойронд орших биологийн төрөл зүйлд эерэг нөлөөллийг бий болгохоор төрийн бус байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд Рио Тинтогийн шинжээчийн заавар, Монгол улсын нийт 70 гаруй хууль, дүрэм журмыг баримтлан, байгаль орчны нөлөөллийг анхааран ажиллаж байна хэмээн Рио Тинто өөрийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан мэдээллэсэн байна.

Олон нийт

Оюу Толгой байгаль орчинг хамгаалахаас гадна орон нутгийн ард иргэдийн амьдралыг сайжруулахад хувь нэмэр оруулахаар олон талын үйл ажиллагаа, санаа санаачилгыг хэрэгжүүлж байгаа бөгөөд Ханбогд сумыг генераторын тусламжтайгаар цахилгаанаар хангаж байсан бол яваандаа уурхайн цахилгааны шугаманд холбосон байна. Мөн түүнчлэн Ханбогд суманд боловсролын болон эрүүл мэндийн байгууламжууд, зам засвар сайжруулалтын ажлууд, төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалтыг хийсээр байгаа ажээ.

Соёлын өв

Соёлын өвийг хамгаалах хөтөлбөр нь уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниуд соёлын, түүхэн болон нийгмийн үнэт нөөц баялгийг хамгаалахад дэмжлэг болох шинэлэг санаачилга бөгөөд энэ нь хүний гараар бүтээгдсэн болон Өмнө Говь дах байгалийн өв соёлыг хамгаалахад зориулагдсан. Энэ ажлын хүрээнд Өмнө Говь аймгийн нутаг дэвсгэр дэх түүхэн ач холбогдол бүхий Дэмчигийн хийдийг зарим хэсгийг сэргээн засварласан, орон нутгийн 100 орчим ахмадууд хойч үедээ үндэсний дуунуудыг сийрүүлэн бичиж үлдээх ажил зэргийг дэмжин ажиллаад байгаа юм байна.

Ирээдүйн хөгжил

Ил уурхайн үйл ажиллагаа өрнөж, анхны хүдэр боловсруулалт, баяжмал тээвэрлэлт амжилттайгаар эхэлсэн боловч Оюу Толгойн цөм баялаг далд уурхайд оршиж байгаа бөгөөд энэхүү газрын гүнд орших баялгийг блокчлон олборлох аргыг ашиглан олборлохоор төлөвлөөд байгаа бөгөөд энэ ч утгаараа Монгол улсын ирээдүйн эдийн засаг, нийгэм, байгаль орчны хөгжилд Оюу Толгой чухал үүрэг гүйцэтгэсээр байх юм.

Тайлагнал

Оюу Толгой компанийн тайлагнал 2003 оноос эхэлсэн бөгөөд нийгэм, байгаль орчин, орон нутгийн гээд олон төрлийн тайлагналуудыг бэлтгэж, олон нийтэд ил тод болгосон байна.

Компани нийт 31 өөр гарчиг бүхий /утга агуулга давхцсан боловч нэр өөр/ тайлагналыг байгаль орчин, орон нутаг, ил бод байдал мөн бусад гэсэн үндсэн 4 ангиллаар бэлтгэн толилуулсан. Үүнээс компани “Оюу Толгойн байгаль орчны хөтөлбөрийн биелэлт” болон “Оюу Толгойн байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө” тайлагналуудыг хамгийн тогтвортой бэлтгэдэг байна. Жил бүр харилцан адилгүйгээр олон нийттэй харилцах, усны хэрэглээний, барилга байгууламжийн зэрэг үнэлгээний тайлангуудыг бэлтгэсэн мөн бэлтгэж олон нийтэд толилуулсан.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөг үнэлэх, түүнийг арилгах, бууруулах арга хэмжээ, төлөвлөгөөг боловсруулахын тулд Нийгэм-эдийн засгийн болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2002 оноос хойш “Оюу толгой”-н лицензийн талбай, түүний үндсэн дэд бүтцийн талбайд хийж ирсэн бөгөөд шаардлагатай хууль тогтоомж, стандарт шаардлагуудтай нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг ба тэдгээрийг дурдвал:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ
- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ
- Хамтын оролцоотой байгаль орчны хяналт, үнэлгээний хөтөлбөр

- Жил тутмын Байгаль орчны тайлан

Компани байгаль орчны удирдлагын ISO14001, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн OHSAS18001 стандартуудын гэрчилгээ авсан ба эдгээр стандартуудыг хангаж буй талаар баталгаажуулсан сертификатуудыг 2013 оны 1 дүгээр сард авсан.

Дээрх хууль дүрэм журмаас гадна Оюу Толгой ОҮИТБС-1-ийн дагуу батлагдсан Ашигт малтмалын олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тайланг тогтмол бэлтгэдэг.

Тогтвортой хөгжлийн тайлангийн хувьд анх 2013 онд бэлтгэж байсан боловч дараах жилүүдэд бэлтгэж олон нийтэд ил тод нийтлээгүй байна. Уг тайлан:

- Өмнөтгөл
- Товч танилцуулга
- Тогтвортой хөгжил яагаад чухал вэ?
- Хамтын ажиллагаа
- Өнө удаан хадгалагдах хөрөнгө оруулалт
- Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа
- Байгаль орчны хамгаалал
- Өсөн хөгжиж буй Өмнөговь аймаг
- Нийгэмд хандсан хөрөнгө оруулалт
- Боловсон хүчний хөгжил
- Залгамж халааг бэлтгэх оюуны хөрөнгө оруулалт
- Бизнес, эдийн засгийн өсөлт
- Үйлдвэрлэл, экспортын тайлан
- Цаашдын зорилт
- Нийгмийн хөрөнгө оруулалтын тухай дэлгэрэнгүй гэсэн бүтэцтэй байна.

Оюу Толгой компанийн тайланг ВНР Billiton компанийн тайлантай харьцуулахад нийгмийн хариуцлагын үндсэн ойлголтуудыг багтаасан боловч нийгмийн хариуцлагын асуудлуудыг ангилж, ойлгомжтой байдлаар хүргээгүй. Энэ нь нэг талаар компанийн үйл ажиллагаанд нийгмийн хариуцлагын бодлого, хэрэгжилт ямар ямар чиглэлээр хэрэгжиж байгаатай шууд холбоотой.

Тайланг ямар нэг стандарт эсвэл зөвлөмжийн дагуу бэлтгээгүй учир оролцогч талууд бусад ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлж буй компаниудтай харьцуулахад хүндрэлтэй байна.

ВНР Billiton тайландаа оролцогч талуудыг онцолж дурдсанаар нэг талаас компанийн үйл ажиллагаа хэнд хамааралтай болохыг ойлгомжтой тайлбарлаж байгаа ба нөгөө талаас оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг хангахаар ямар үйл ажиллагааг явуулдаг талаар мэдээлэл өгч байгаа юм. Оюу Толгой компанийн хувьд чухалд тооцогдох оролцогч талууд болох хэвлэл мэдээлэл, ажилчид, засгийн газар, иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс үйл ажиллагааны ил тод байдлыг шүүмжлэх асуудал байсаар байгаа. Энэ нь ихэнхдээ мэдээллийн ил тод бус байдал, үйл ажиллагааны тайланг тогтмол танилцуулдаггүй зэрэг шалтгаануудаас үүдэж байгаа нь ажиглагддаг.

ДҮГНЭЛТ

Ерөнхий дүгнэлт:

- Компанийн нийгмийн хариуцлагын тухай ойлголт олон улсад хүчтэй яригдаж, нийгэм байгаль орчин, хүрээлэн буй хүмүүст эерэг нөлөөллийг бий болгох, мөн ирээдүй хойч үедээ баялгийг бүтээх боломжийг олгох гэх мэт нийгмийн хариуцлага гэдэг нэр томьёо зөвхөн тодорхойлолт төдий бус маш өргөн цар хүрээг хамарсан хөдөлгөөн, хариуцлага, зориулалт болоод байна.
- Олон улс, үндэстэн дамнасан корпорациуд бий болж, тэдгээрийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх арга хэрэгслийн хэрэгцээ улам бүр нэмэгдсээр байна.
- Тогтвортой хөгжлийн тайлагнал, Нэгдмэл тайлагналын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх туршлага олон улсад түгээмэл байна.

- Улс орнуудын төр засаг, бизнесийн орчин, засаглал, зохицуулалтын ялгаатай байдлаас хамаарч нийгмийн хариуцлагын тайлагналыг сайн дурын болон заавал тайлагнах хэлбэрээр хэрэгжүүлж байна.
- Нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаа нь компанийн нэр хүндийг өсгөж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхээс гадна дотоод үйл ажиллагааны үр ашигтай байдлыг сайжруулж зардал хэмнэх боломжуудыг бий болгодог.
- Нийгмийн хариуцлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр компани учирч болзошгүй эрсдэлүүдийг ойлгох, сэргийлэх боломжтой.
- Манай орны хувьд нийгмийн хариуцлагын тайлагналын орчин бүрэн бүрэлдээгүй, дүрэм журам, нэгдсэн зохицуулалтын механизм бий болоогүй байгаа бөгөөд компаниуд ихэнхдээ сайн дурын үндсэн дээр нийгмийн хариуцлагын тайланг бэлтгэж олон нийтэд толилуулж байгаа бөгөөд уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагатай байдал дутагдалтай байгаа нь нэг талаас нийгмийн хариуцлагын ач холбогдлыг бүрэн ойлгодоггүйгээс харагдаж байна.

“Оюу толгой” ХХК-д хийсэн судалгааны дүгнэлт:

- Оюу Толгой Компани тогтвортой хөгжлийн тайланг 2013 оны гүйцэтгэл дээр үндэслэн бэлтгэсэн.
- Тайланг агуулгын хувьд харахад ямар нэг, стандарт дүрэм журам, хуулийн заалтын хүрээнд бэлтгэсэн талаар тодруулга байхгүй байна.
- Оюу толгой компанийн тайланд баталгаажуулах үйлчилгээ хийгдээгүй учир мэдээллийн үнэн бодит, ил тод, найдвартай байдалд үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй байна.
- Салбарын хэмжээнд нийгмийн хариуцлагын болон тогтвортой хөгжлийн тайлангууд ховор байгаа бөгөөд өмнө нь ижил төстэй тайлан бэлтгэгдэж байгаагүй, харьцуулан дүгнэлт хийх боломж бага байна
- Олон улсын туршлагатай харьцуулахад компани оролцогч талуудын хамтын ажиллагааг тусгайлан тодорхойлж, тэдний хүсэл сонирхолд хэрхэн нийцүүлж ажиллаж байгааг нарийн тайлагнаагүй
- Одоогийн байдлаар компанийн санхүүгийн тайлан ил тод нийтлэгддэггүй бөгөөд сонирхлын бүлгүүдийн хэрэгцээг хангахын тулд санхүүгийн болон нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн тайлагналыг багтаасан нэгдмэл тайланг толилуулах шаардлагатай байна.

САНАЛ

- Компанийн нийгмийн хариуцлагатай буюу тогтвортой хөгжлийн асуудлыг оролцогч талуудын ашиг сонирхол нийцүүлэн үйл ажиллагаандаа тусгах, алсын хараа, үнэт зүйлс, зорилго зорилттойгоо нийгмийн хариуцлагыг уялдуулах.
- Материаллаг бөгөөд чухал асуудлуудыг тодорхойлох. Гол үйл ажиллагаа, санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллүүдийг тодорхойлсноор тайлангын бүтцийг тодорхойлох.
- Тайлагналыг ил тод болгох, тогтмол тайлагнах.
- Тайлагналын эргэх холбоог сайжруулж оролцогч талуудтай байнгын харилцаа холбоотой ажиллах, тэдний санал сэтгэгдлийг сонсох, хамтран ажиллах.
- Үйл ажиллагаанд хэрэгжиж буй нийгмийн хариуцлагын төсөл, хөтөлбөр, ажлуудыг олон улсын туршлагатай харьцуулах, сайжруулах, төрөлжүүлэх ажиллагааг тасралтгүй явуулах.

НОМ ЗҮЙ

2. (2014 оны 5 7). "компанийн засаглалын кодекс"-ийг шинэчлэн батлах тухай, дугаар 162. Санхүүгийн зохицуулах хороо.
3. Citizenship, e. &. (2013).
4. EY. (2014). EY's excellence in integrated reporting awards 2014.
5. Farcas, t. V. (2015). Development of corporate reporting over time: from a traditional system to an integrated system.
6. Gri. (2013). The sustainability content of integrated reports- a survey of pioneers.
7. IIRC. (2013). The international ir framework.
8. Jones, h. (2010). Sustainability reporting matters: what are national governments doing about it?

9. Julia catarina jensen and nicola. (2011). Determinants of traditional sustainability reporting versus integrated reporting. An institutionalis approac.
10. Steve lydenberrg, jean rogers, david wood. (огноо байхгүй). From transparency to performance.
11. Www.csr.mn. Компанийн нийгмийн хариуцлага.-ээс гаргасан
12. АМГ. (2014). Геологи, уул уурхайн салбарын мэдээллийн товхимол 2014 эхний хагас жил.
13. Ашигт малтмалын газар. (<http://www.mram.gov.mn/>)
14. Р.бадамханд. (2014). Уул уурхайн нягтлан бодох бүртгэлийн онцлог. (д. Нямаа, хян.) Улаанбаатар.
15. ҮСХ. (2015). Ажиллах хүчний 2015 оны 2 дугаар улирлын судалгааны товч танилцуулга .

I. ХАВСРАЛТ

Уул уурхайн компаниудын НХТ

Компанийн нэр	Компанийн төрөл	НХТ олон нийтэд тайлагнадаг эсэх
Оюу Толгой	ХХК	Тийм (цахим хэлбэрээр 2013 он)
Энержи Ресурс	ХХК	Тийм (цахим хэлбэрээр 2013 он)
Эрдэнэт	ХХК	Үгүй
Бороо Гоулд	ХХК	Үгүй
Адуунчулуун	ХК	Үгүй
Багануур	ХК	Үгүй
Шивээ Овоо	ХК	Үгүй